



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛПЫН ЯМ



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ


ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ
ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨР

БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ

Хамрагдах иргэд:*



Ажилгүй иргэн



Хувиараа хөдөлмөр
эрхлэгч иргэн



Нөхөрлөл,
хоршоо, аж ахуйн
нэгжийн хэлбэрээр
бичил бизнес
эрхлэгч иргэн

- * Аймгийн төвийн иргэдэд илүүтэй зориулсан, сумын иргэд хамрагдсан тохиолдолд зээлийн өмнөх сургалт, зээлийн дараах санхүүгийн бус дэмжлэгт хамрагдах унааны болон аймагт байх зардлаа өөрөө хариуцна.

2019 он

ЗОРИЛГО:

Бичил бизнес эрхлэгч таны аж ахуйн тогтвортой үйл ажиллагаа эрхлэх чадавхыг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, цаашид тогтвортой хадгалахыг дэмжих

БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ НЬ ДАРААХ З БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГТЭЙ:

1. ЗЭЭЛИЙН ӨМНӨХ СУРГАЛТ - 2 өдөр



Жижиг зээл авахын тулд та энэ сургалтад заавал хамрагдана. Сургалтаар:

- Бизнес санаагаа хөгжүүлнэ,
- Бичил бизнесийг дэмжих жижиг зээлийн нөхцөл, шаардлагыг мэднэ,
- Бизнесийн төслийн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний заавартай танилцана,
- Бизнесийн төсөл боловсруулах арга, аргачлалд суралцана.

2. ЖИЖИГ ЗЭЭЛ

- Зээлийн хэмжээ 5-10 сая төгрөг хүртэл, 24 хүртэл сарын хугацаатай, жилийн 7.2 хувийн хүйтэй.
- Зээлийг банкаар дамжуулан олгоно.
- Эхний 2 сард зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлнө.
- Зээл хүсэгч 40 хувийн барьцаа хөрөнгөтэй байна.



3. ЗЭЭЛИЙН ДАРААХ САНХҮҮГИЙН БУС ҮЙЛЧИЛГЭЭ



Жижиг зээл авсан иргэд үнэ төлбөргүйгээр заавал хамрагдана:

- Бизнес хөгжлийн 7 өдрийн 50 цагийн сургалт (бизнесийн хурдасгуур, санхүүгийн бүртгэл, маркетинг, борлуулалт гэх мэт)
- Бизнесийн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөн туслах 20-30 цагийн үйлчилгээ (бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалт, менежмент, ментор гэх мэт)

БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНД ХАМРАГДАХ 9 АЛХАМ



1. Хэрэв та тус арга хэмжээнд хамрагдахыг хүсвэл аймгийнхаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (ХХҮГ)-т оорийн биеэр ирж, мэдээлэл аваарай.



2. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд хамрагдах бүртгэлийн маятныг хариуцсан мэргэжилтнээс авч бүртгүүлээрэй.



3. Зээлийн өмнөх сургалтад хамрагдаарай. Сургалт сондгой сар бүрийн 15-ны дотор зохион байгуулагддаг. Гэхдээ сургалтын тоөвиг холбоодох мэргэжилтнээс лавлана уу.



4. Бизнесийн төслийн бичих загварыг ХХҮГ-ын мэргэжилтнээс авч, сургалтаас авсан мэдээлэлдээ тулгуурлан төслөө боловсруулаарай.

- 5.** Бизнесийн төслөө шаардлагын дагуу боловсруулж, бэлэн болсон гэж үзвэл ХХҮГ-ын хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэж өгөөрэй. Төслийг сондгой сар бурийн 30-ны дотор хүлээн авна.



- 6.** Таны төслийг ХХҮГ-ын ажлын хэсэг батлагдсан аргачлалын дагуу урьдчилан үнэлж, "Маш сайн төсөл", "Шаардлага хангасан төсөл", "Шаардлага хангаагүй төсөл" гэж ангилаад нийтэд мэдээлнэ. Төслийн шалгаруулалтыг тэгшиг сар бурийн 20-ны өдрөөс өмнө зохион байгуулна.
- 7.** Хэрэв "Маш сайн төсөл" гэж үнэлэгдвэл банканд шууд илгээгдэнэ. "Шаардлага хангасан төсөл" гэж үнэлэгдвэл зээлийн сангийн үлдэгдэлтэй уялдуулан, ажлын хэсэг шаардлагатай бол санамсартгүй түүврийн аргаар сонгож банк руу илгээнэ.

- 8.** Зээл олгох банк төслүүдийг хүлээж аваад өөрийн шалгуураар дахин үнэлж, жижиг зээл олгох эсэхээ бие даан шийдвэрлэнэ.



- 9.** Та жижиг зээл авсан бол ХХҮГ болон санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх байгууллагатай гуравласан гэрээ байгуулж, санхүүгийн бус үйлчилгээнд заавал хамрагдаарай.

